



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 20

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.4 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Төв халхын дуулалт жүжгийн театрийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 5,784,851 (таван сая долоон зуун наян дөрвөн мянга найман зуун тавин нэг) төгрөгийн балансын үнэтэй, 4,285,829,32 (дөрвөн сая хоёр зуун наян таван мянга найман зуун хорин есөн төгрөг гучин хоёр мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөгтэй 15 нэр төрлийн 35 ширхэг хөрөнгийг хавсралтын дагуу акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга (Д.Доржсүрэн)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1. Үндсэн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор акталж, данс бүртгэлээс хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3 Энэ тогтоолын биелэлтийг 2024 оны 5 дугаар сард багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2024 оны 04 дүгээр сарын 22-ний өдрийн
Тогтоолын хавсралт



Төв халхын дуулалт жүжгийн театрийн актлах хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	ш	тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Данснаас хасах болсон шалтгаан	Актлах төрөл
1	Хурлын индер	6/30/2023	ш	1	20,250	20,250	3,037.50	17,212.50	муу	1.Устгах
2	Ятга их гар	6/30/2023	ш	1	281,200	281,200	42,180.03	239,019.97	муу	1.Устгах
3	Онон хивс	6/30/2023	ш	3	30,000	90,000	13,500.00	76,500.00	муу	1.Устгах
4	Лимбэ хөгжим	12/30/2023	ш	1	98,600	98,600	2,465.01	96,134.99	муу	1.Устгах
5	Морин хуурын путлер	12/30/2023	ш	1	85,000	85,000	2,124.99	82,875.01	муу	1.Устгах
6	Тольтой түмбүчик	4/1/2014	ш	8	100,000	800,000	726,665.07	73,334.93	муу	1.Устгах
7	Гоцлол труба	6/30/2023	ш	1	63,315	63,315	15,828.75	47,486.25	муу	1.Устгах
8	Гармон хөгжим	6/30/2023	ш	1	119,120	119,120	22,335.03	96,784.97	муу	1.Устгах
9	Клюстэй транбон	6/30/2018	ш	1	20,000	20,000	11,500.23	8,499.77	муу	1.Устгах
10	Тоос сорогч	6/30/2023	ш	1	255,000	255,000	38,250.00	216,750	муу	1.Устгах
11	Пким кино аппарат	12/30/2023	ш	2	1,125,000	2,250,000	187,500.00	2,062,500	муу	4.Бусад
12	Угаалгын машин	11/2/2020	ш	1	399,900	399,900	273,265.00	126,635	муу	1.Устгах
13	Түмбүчик дуу анги	6/30/2023	ш	8	52,808	422,466	63,370.08	359,095.92	муу	1.Устгах
14	Морин хуур	12/30/2023	ш	1	280,000	280,000	6,999.99	273,000.01	муу	1.Устгах
15	Гэрийн шар бүрээс	6/30/2023	ш	4	150,000	600,000	90,000.00	510,000	муу	1.Устгах
Нийт дүн				35	3,080,193	5,784,851	1,499,022	4,285,829.32		